*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ЗҮЛЭГТ 12 ДУГААР БАГИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН ОДСҮРЭНГИЙН МӨНХЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Хүрэх түвшин | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангаан ажиллах”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.Өрхийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах | 1.1.1.Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй өрхийн орлого нэмэгдүүлсэн өрхийн тоогоор | 8 | 23 10 | “Зүлэгт” 12 дугаар багт хүнсний эрхийн бичигт хамрагддаг 33 өрх байна.<br>Малжуулах төсөлд 1, байнгын ажилд 5, түр ажилд 15 иргэнийг холбон зуучилж нийт 21 иргэний өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.Нийт 23 өрхийн өрхийн орлого нэмэгдсэн байна.<br>Өмнөх оны энэ үетэй харьцуулахад 15 өрхөөр өсөлттэй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ” сургалтад хүнс тэжээлийн хөтөлбөрт хамрагддаг 20 иргэн хамрагдсан. Дэлхийн зөн Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Уран гар” оёдлын практик суралтад 2 иргэн хамрагдаж цахилгаан оёдлын машинаар урамшуулсан. Нийт 32 | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэнийг сургалт, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучилсан.Амьжиргааны түвшин дээшилсэн 2 өрхийг хүнс тэжээлийн хөтөлбөрөөс түдгэлзүүлсэн.Хүнсний эрхийн бичигт хамрагддаг 31 өрхтэй болсон байна. | | |
| | | 1.1.2.Түр болон нийтийг хамарсан ажлын байранд зуучилсан иргэний тоогоор | 15 | 15 | Нийтийг хамарсан ажилд:Нийтийн эзэмшлийн газар мод тарих 5, наадмын талбайд ажиллах 2, нийт 7иргэн.<br>Улирлын чанартай түр ажилд: Өв-санаад 1, “Найдвар” худалдааны төвд үйлчлэгч 1, “Молор” худалдааны төвд худалдагч 1, ”Хишиг-Хурах” дэлгүүрт 1, “Мөнгөн өргөө”-д мод шуудайлах 1, “Итгэл” талх нарийн боовны үйлдвэрт савлагч 1,“Төгөл” барилгын дэлгүүрт туслах 1, нүүрс шигших ажилд 1, нийт 8 иргэн.<br>Түр болон нийтийг хамарсан ажилд 15 иргэнийг холбон зуучилсан. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2.Багийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд баяжилт хийж, хөдөлмөр эрхлээгүй иргэдийг сургалтад хамруулах, ажилд зуучлах | 1.2.1.Хөдөлмөрт бэлтгэх болон мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухааны сургалтад хамрагдсан иргэдийн хувиар | 20 | 23 | Хөдөлмөр эрхэлдэггүй 132 иргэний судалгаанд баяжилт хийв.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ” сургалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 12 нийт 14 иргэн хамрагдсан. Дэлхийн зөн Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Уран гар” оёдлын практик суралтад хөдөлмөр эрхэлдэггүй 5 иргэн хамрагдсан.Эмэгтэйчүүдийн уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхийг бэхжүүлэх төсөл | 2025.01.02<br>2025.11.28 | 65 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжиж "Даавуун тор" нөлөөллийн сургалтад гэрээр оёдол хийдэг 3 иргэн хамрагдсан. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн журмын танилцуулга "Төсөл бичих аргачлал" сургалтад 3 иргэн хамрагдсан.ХХҮГазарт үсчингийн сургалтад хамрагдах хүсэлтэй 5 иргэний судалгаа өгсөн боловч анги нь хүн бүрдээгүй учраас хичээллээгүй, албан хаагчаас хамаарахгүй шалтгаанаар хугацаа хоцорсон.Нийт 39 иргэн хамрагдах байснаас 30 иргэн хамрагдаж 23 хувьтай байна. | | |
| | | 1.2.2.Байнгын болон улирлын чанартай ажлын байранд зуучилсан иргэдийн тоогоор | 4 | 5 | Байнгын ажилд "Хишиг-Хурах" хүнсний дэлгүүрт 2, Их богд" хоолны газар үйлчлэгч бэлтгэгч 1, "Онги ус" сувагт үйлчлэгч 1, "Буриад" талхны үйлдвэрт талх баригч 1 нийт 5 иргэнийг холбон зуучилсан. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |
| | | 1.2.3.Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлсэн иргэдийн тоогоор | 13 | 16 | Хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн судалгаанд баяжилт хийв. Нийт 128 иргэн байгаагаас үүнээс 42 иргэн сайн дурын нийгмийн даатгал төлдөг. Жилийн эцсийн байдлаар малчидаас даатгалд 16 иргэн хамрагдсан. Өмнөх оны энэ үетэй харьцуулахад 3 иргэнээр өссөн дүнтэй байна. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |
| | Арга хэмжээ 1.3.Ахмад настны нийгмийн оролцоог хангах | 1.3.1.Хөдөлмөр эрхэлдэг ахмад настны судалгаанд баяжилт хийсэн тоогоор | 15 | 25 | 139 өрхийн 170 ахмад байгаагаас эрэгтэй 50, эмэгтэй 120 байна. Хөдөлмөр эрхэлдэг 25 ахмадын дэлгэрэнгүй судалгаа гарган баяжилт хийв.Жилийн эцсийн байдлаар хөдөлмөр эрхэлдэг ахмадын тоо араваар өссөн байна. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | | 1.3.2.Хөдөлмөр эрхэлдэг ахмад настны хувиар | 100 | 90 | Нийт ахмадын 17 хувь нь хөдөлмөр эрхэлдэг.Хөдөлмөр эрхлэх боломжтой 28 ахмадын судалгаа гаргасан, үүнээс 90 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. | 2025.01.02 2025.11.28 | 100 |
| | | 1.3.3.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахаар ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 80 | 100 | Нийгмийн халамжийн үйлчилгээнээс харъяалалгүй ахмадуудад жилд 2 удаа олгогддог мөнгөн тэтгэмжид 05 сард 124, 10 сард 141 ахмад хамрагдсан.Насны хишигт 3, тусгай хэрэгсэлд суултуур 4, хөтөвч 3, шүд 5, сонсголын аппарат 4, бүс 14, бөөрний даруулга 9, нурууны даавуун хамгаалалт 1 нийт 43. Хужирт сувилалд 3, Өгөөмөр сувилалд 15 нийт 18. Байнгын асрагаанд нийт 23 ахмад байгаагаас амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар байнгын асрагаанд шинээр орсон 5, байнгын асрагааны сунгалт 5 хийгдсэн. Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих цогц үнэлгээнд 70 ахмад хамрагдсан.Давхардсан тоогоор нийт 242 ахмадыг нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучилсан. | 2025.01.02 2025.11.28 | 100 |
| | Арга хэмжээ 1.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах | 1.4.1.Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 3 | 9 | 1.Багийн ажлын албанаас "Удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөн үр удамдаа үлдээх" сургалт<br>2.Багийн ажлын албанаас "Цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сургалт<br>3.Арвайхээр сумын ЗДТГазар "Зүрх сэтгэлийн боловсрол олгох ба цахим ур чадварыг нэмэгдүүлэх" сургалт<br>4.ХХҮГазар "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх | 2025.01.02 2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | | | | | үйлчилгээ" сургалт<br>5.Арвайхээр сумын ЗДТГазар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 5 төрөлт тэмцээн<br>6.Арвайхээр сумын ЗДТГазар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд урлагын тэмцээн<br>7.Арвайхээр сумын ЗДТГазар, Уянсэтгэл ӨЭМТөвтэй хамтран "Хүний эрх-Хүртээмжтэй оролцоо" сарын аяны хүрээнд хэвтэрт байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр гэр айлчлал хийсэн.<br>8.Залилах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Сонголт таны гарт" панел хэлэлцүүлэг<br>9."Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн хүрээнд УИХ-ын гишүүн Ж.Баясгалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хийсэн уулзалт | | |
| | | 1.4.2.Хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувиар | 50 | 90 | 18-с дээш насны хөгжлийн бэрхшээлтэй 50 иргэн байна.<br>1."Удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөн үр удамдаа үлдээх" сургалтад 3<br>2."Цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сургалтад 2<br>3.Зүрх сэтгэлийн боловсрол олгох ба цахим ур чадварыг нэмэгдүүлэх" сургалтад 10 иргэн хамрагдсан.<br>4."Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ" сургалтад 3<br>5.Арвайхээр сумын ЗДТГазар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 5 төрөлт тэмцээнд 8 | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 6.Арвайхээр сумын ЗДТГазар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд урлагын тэмцээнд 3<br>7.Арвайхээр сумын ЗДТГазар, Уянсэтгэл ӨЭМТөвтэй хамтран "Хүний эрх-Хүртээмжтэй оролцоо" сарын аяны хүрээнд хэвтэрт байдаг хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийд гэр айлчлал хийсэн.<br>8.Залилах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Сонголт таны гарт" панел хэлэлцүүлэгт 1<br>9."Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн хүрээнд УИХ-ын гишүүн Ж.Баясгалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хийсэн уулзалтад 13 иргэн хамруулсан.Нийт 9 арга хэмжээнд давхардсан тоогоор 45 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 90 хувийн хамрагдалттай байна. | | |
| | | 1.4.3.Соёл урлаг, спорт бусад арга хэмжээнд хамруулсан хувиар | 50 | 60 | 5."Эртэч ахмад" эрүүл зөв хооллолт, шугаман бүжиг, дасгал хөдөлгөөн, алхалтыг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэн оролцсон.<br>6."Өвөрхангай марафон-2025" бүх нийтийн арга хэмжээнд 4,<br>5.Арвайхээр сумын ЗДТГазар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 5 төрөлт тэмцээнд 8<br>6.Арвайхээр сумын ЗДТГазар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд урлагын тэмцээнд 5 нийт 21 иргэн оролцсон.<br>Соёл, урлаг спортын арга хэмжээнд оролцох боломжтой 36 иргэнээс | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | давхардсан тоогоор нийт 21 иргэн хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтнй иргэдээс 60 хувийн хамрагдалттай байна. | | |
| | | 1.4.4.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахаар ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 100 | 100 | Хөгжлийн бэрхшээлтэй 56 иргэн байгаагаас төрөлхийн 28, олдмол 28, байнгын асаргаатай насанд хүрсэн иргэн 7, хүүхэд 6 байна. Амьжиргаа дэмжих хурал 16 удаа хуралдаж үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асаргааны сунгалт 7, шинээр асаргаанд орсон 2 нийт 9 материал дэмжигдсэн.Төсөл хөтөлбөрт 1, ЭНЭМҮТөвд үзлэг шинжилгээнд хүүхэд 3, унааны зардлын хөнгөлөлтөд хүүхэд 5, живхний хөнгөлөлтөд хүүхэд 1, түлшний үнийн хөнгөлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 6, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 9 нийт 25 иргэний материал дэмжигдсэн. ХХҮГазраас зарласан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ" төслийн хүрээнд "Ариунсанаа" эмнэлэгт эдгэшгүй хүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн 8, хүүхэд 3 нийт 11 иргэний судалгаа өгч холбон зуучилсан."Элбэрэлт мед" эмэгтэйчүүдийн эмнэлэгт үзлэгт 7 эмэгтэйг хамруулсан.Давхардсан тоогоор нийт 52 иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулан ажиллав. | 2025.01.02 2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувиар | 100 | 84 | Хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхэд байгаагаас сургуулийн өмнөх боловсролд 1, тусгай сургуульд, цэцэрлэгт 1, гэрт 1, ЕБСургуульд 3 хүүхэд суралцаж байна. Гэрт байгаа хүүхэд нь тусгай цэцэрлэгт явж байгаад 11 нас хүрсэн учир 2025 онд хамрагдаагүй болно. Сургууль, цэцэрлэгийн хамрагдалт 83,3 хувьтай байна. | 2025.01.02<br>2025.11.28 | 84 |
| 5. | Арга хэмжээ 1.5.Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх, үнэлгээ хийх дүгнэлт гаргах | 1.5.1.Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлд гэр айлчлал хийсэн өрхийн хувиар | 100 | 100 | 12 дугаар баг нь 506 өрх, 1737 иргэнтэй. Үүнээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй, архины хамааралтай хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй бага насны хүүхдүүдтэй 35 өрхийн судалгаа гарган 4 удаагийн давтамжтай удаа гэр айлчлал хийн хяналт тавин ажилласан.Мөн багт бүртгэлтэй болон бүртгэлгүй 52 түр оршин суугчаар гэр айлчлал хийн эрсдэлт нөхцөлд байгаа 4 өрхийг илрүүлэн бүртгэн авч хяналт тавьж ажилласан.Нийт 87 өрхөөр гэр айлчлал хийсэн. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |
| | | 1.5.2.Хаагдсан кейсийн хувиар | 100 | 100 | Жилийн эцсийн байдлаар хүүхэд хамгааллын хамтарсан баг 7 кейс дээр ажилласан. Үл хайхрах 5, гэр бүлийн гишүүдийн хоорондын үл ойлголцол 2. Хүүхдийн тусламжийн 108 утсанд бүртгэгдсэн 4, хамтарсан баг илрүүлсэн 3. Кейстэй өрхүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн насны үечлэлийг графикаас харахад 0-6 насны 3 хүүхэд, 7-11 насны 3 хүүхэд, 12-16 насны 5 хүүхэд байна.Үүнээс 6 | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | кейсийг хааж кейс шийдвэрлэлтийн хувь 85.7 хувьтай байна.Өмнөх оны энэ үетэй харьцуулахад 55 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | | |
| | | 1.5.3.Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 4 | 1.”Өвөрхангай марафон-2025” бүх нийтийн арга хэмжээнд “Үер усны ослоос урьдчилан сэргийлэх” 20 ширхэг тараах материал хэвлэн гаргаж тараасан.<br>2.Багийн ажлын албанаас ”Цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хүүхдээ цахим хэрэглээнээс татгалзах урьдчилан сэргийлэх, хамгаалах нөлөөллийн сургалт зохион байгуулж 35 иргэн хамрагдсан.<br>3.Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Хүүхэд, залуучуудыг электрон тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээий тухай” 01 дүгээр албан даалгаврын 4.2 дахь заалтыг үндэслэн “Ашиг биш хариуцлагаа эрхэмлэе” аяныг өрнүүлж 12 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 12 хүнсний дэлгүүрийг гарын үсэг зуруулж 100% нэгдүүлсэн. Утаат тамхи худалдаалдаг 7 хүнсний дэлгүүр татгалзсан.”Зүлэгт”12 дугаар баг Фэйсбүүкт нөлөөллийн reel хийж байршуулсан.<br>4.Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас “Хүүхдийн төлөө илүү хариуцлагатай, илүү сонор байцгаая” уриалгыг дэвшүүлэн зөвлөгөөн зохион байгуулсан. Тус | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөгөөнд 12 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг 3 хүнсний дэлгүүрийн төлөөлөл оролцсон. | | |
| | | 1.5.4.Эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд сургалт зохион байгуулсан тоогоор | 2 | 5 | 1.Багийн ажлын албанаас "Хууль ба амьдрал" сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулж, багийн 20 иргэн, 15 хэсгийн ахлагч нийт 35 иргэн хамрагдсан.<br>2.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан багийн ажлын албанаас санаачилан "Хайр түгээе-Инээд бэлэглэе" арга хэмжээ зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 3 дугаар цэцэрлэгийн урлаг зааланд эцэг, эхчүүдийг хүлээн авч "Гэр бүлийн үнэ цэнэ" сургалт зохион байгуулж нийт 53 асран хамгаалагчдыг хамруулсан.<br>3.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах, татгалзах дадлыг бий болгох үүднээс Арвайхээр сумын ЗДТГ, 13 багийн ажлын алба хамтран "Гэр бүлийн үнэ цэн","Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, хүлээх хариуцлага, "Хүний үндсэн эрх, үүрэг ба хариуцлага", "Өөрөө өөртөө туслах бүлэг" сэдэвт сургалт зохион байгуулагдсан.<br>4.Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр нь жил бүрийн 4 дүгээр сарын 30-нд тэмдэглэгддэг. Энэхүү өдрийг угтан "Хариуцлагатай | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эцэг, эх байя" сургалтыг Арвайхээр сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудын санаачилгатайгаар ХГБХХГ,Арвайхээр сумын 13 багийн ажлын алба хамтран зохион байгуулагдсан.12 дугаар багаас 8 иргэн хамрагдав.<br>5.ХГБХХГазраас "Зөв дадал-Эрүүл ирээдүй" сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан. Тус нөлөөллийн үйл ажиллагаа нь хүүхдийг хорт зуршил, архи, согтууруулах ундаа, утаат болон электрон тамхи, бусад төрлийн мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой. 6 иргэн хамрагдсан. | | |
| | | 1.5.5.Хайрлагдсан хүүхэд төслийн хэрэгжилтийн хувиар | - | 100 | 1."Халуун ам бүл","Хайрлагдсан хүүхэд" төслийн уулзалт хэлэлцүүлэг сургалтад багийн ажлын алба хамрагдсан.<br>2.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой "Халуун ам бүл 1", хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх бодлогыг салбар дундын хамтын ажиллагаатай хэрэгжүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулах зорилготой "Хайрлагдсан хүүхэд" төслийн | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уулзалт сургалт Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас зохион байгуулсан.Уг төслийн уулзалт, сургалтад 7 иргэн хамруулсан. Энэхүү төсөл нь 2025-2029 он хүртэл 4 жилийн хугацаатай, төслийн төлөвлөгөө нь хугацаандаа аймгаас баталгаажиж ирээгүй тул албан хаагчаас хамаарахгүй шалтгаанаар хугацаа хоцорсон. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6.Гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 1.6.1.Залуу гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт арга хэмжээний тоогоор | 1 | 5 | 1.Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Арвайхээр сумын ЗДТГазар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран “Хайраар холбогдсон амьдрал” нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж багаас 3 гэр бүлийн 6 иргэн хамрагдсан.<br>2.Арвайхээр сумын ЗДТГазар, ХГБХХГазар, Цагдаагийн газар, Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулсан “Аз жаргалтай гэр бүл” вакум сургалтад 1 гэр бүл оролцсон.<br>3.Арвайхээр сумын ЗДТГазраас зохион байгуулсан ”Удмаа хайрлая, хуураа дээдлэе” сургалт арга хэмжээнд 3 гэр бүлийн 6 иргэн оролцсон.<br>4.”Халуун ам бүл-1”, “Хайрлагдсан хүүхэд” төслийн хэлэлцүүлэг арга хэмжээнд 5 гэр бүлийн 7 иргэн оролцсон.<br>5.”Халуун ам бүл” контентын уралдаанд 1 гэр бүл оролцсон. Нийт 12 гэр бүл хамрагдсан байна. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |
| | | | | | 1.“Халуун ам бүл”, “Хайрлагдсан хүүхэд” төслийн уулзалт хэлэлцүүлэг сургалтад багийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.6.2.Халуун ам бүл төслийн хэрэгжилтийн хувиар | - | 100 | ажлын алба хамрагдсан.<br>2.1500 дагагчтай “Зүлэгт” 12 фэсбүүкт хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг ашигладаг, хүүхдүүдээ хөдөлмөрт сургаж буй нэг гэр бүлийг оролцуулж контент хийн байршуулан 1200 хандалт авсан байна.Мөн Өвөрхангай аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газар фэсбүүк хуудаст тус контентыг байршуулан 13600 хандалт авснаар бусад гэр бүлд нөлөөлүүлснээр гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлсэн.Энэхүү төсөл нь 2025-2029 он хүртэл 4 жилийн хугацаатай, төслийн төлөвлөгөө нь хугацаандаа аймгаас баталгаажиж ирээгүй тул албан хаагчаас хамаарахгүй шалтгаанаар хугацаа хоцорсон. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |
| 7. | Арга хэмжээ 1.7.Иргэдийг хорт зуршил, мансууруулах бодис, электрон тамхины хэрэглээг багасгах, сурталчилан таниулах | 1.7.1.АА (Архичид Аминчлахуй) бүлэгтэй хамтран ажилласан арга хэмжээний тоогоор | 1 | 4 | 1.Сэтгэц нийгмийн сэргээн засах төв, Миннесота нийгэмлэг ТББ, Өвөрхангай аймаг дахь архидалт мансуурлын эсрэг ассоциацийн салбар НҮТББ-аас зохион байгуулсан архины хамааралтай хүнд үзүүлэх сэтгэц нийгмийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах сургалтад хамрагдсан.<br>2.”Актив мед” сэтгэц наркологийн эмнэлэгийн донтолтын эмч Т.Түвшинжаргал “Архины хамааралтай хүнд туслах” сургалт зохион байгуулж хэрхэн ажиллах арга зүйн зөвлөгөө өгсөн сургалтад хамрагдсан.<br>3.Арвайхээр сумын ЗДТГазраас | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээ зохион байгуулагдсан. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, зан үйлд эерэг нөлөө үзүүлэх, тэдний өөрийгөө хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн анхан шатны үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилготой.Тус сургалт, арга хэмжээнд архины хамааралтай 2, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 1, зорилтот бүлгийн 1, нийт 5 иргэн хамруулсан.<br>4.Ариунсанаа эмнэлэгт ХХҮГазраас зарласан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ" төслийн хүрээнд архины хамааралтай 1 иргэнийг хамруулан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ авсан. | | |
| | | 1.7.2.Хорт зуршил, мансууруулах бодисын хэрэглээг багасгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоогоор | 2 | 8 | 1.Аймгийн ХГБХХГ-аас санаачлан Цагдаагийн газартай хамтран "Эрүүл нийгмийг бүтээхүйд эрчүүдийн оролцоо" нэртэй өдөрлөгийг аймгийн ЗДТГ, Насан туршийн суралцахуйн төвөөс дэмжин оролцож, нийгмийн салбар бүрээс эрэгтэйчүүдийг хамруулан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, үүрэг хариуцлагын сэдвээр мэдлэг, мэдээлэл олгосон. Тус сургалтад архины хамааралтай 1, бусдад нөлөөлөх хэсгийн ахлагч 2 нийт 3 иргэн оролцов.<br>2.Архины хамааралтай 7 өрхөөр 3 удаа гэр айлчлал хийн архи, тамхины хор хөнөөлийн талаар | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэлтгэсэн тараах материал өгч, зөвлөмж өгч ажилласан.<br>3.Багт үйл ажиллагаа явуулдаг 3 усан сан, 11 хүнсний дэлгүүр, 2 автобусны буудал, 1 тоглоомын талбайд архи, тамхины хор хөнөөлийн талаар 4 төрлийн 40 ширхэг постер 3 удаа мэдээллийн самбарт байршуулж, 265 брошур бэлтгэн тараасан.<br>4.”Ашиг биш хариуцлагаа эрхэмлэе” аяны хзрээнд 7 дэлгүүрийн эзэд электрон тамхи худалдахгүй байх уриалгад нэгдсэн нөлөөллийн видеоконтентыг хийж “Зүлэгт” 12 дугаар багийн фэзсбүүкт байршуулсан.<br>5.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас “Хүүхдийн төлөө илүү хариуцлагатай, илүү сонор байцгаая” уриалгыг дэвшүүлэн зөвлөгөөн зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд 12 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг 3 хүнсний дэлгүүрийн төлөөлөл оролцсон.<br>6.”Өвөрхангай марафон-2025” бүх нийтийн арга хэмжээнд “Электрон тамхины хор уршиг” 30 ширхэг тараах материал бэлтгэн тараасан.<br>7.ХГБХХГазраас “Зөв дадал-Эрүүл ирээдүй” сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан. Тус нөлөөллийн үйл ажиллагаа нь хүүхдийг хорт зуршил, архи, согтууруулах ундаа, утаат болон электрон тамхи, бусад төрлийн мансууруулах бодис хэрэглэхээс | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урьдчилан сэргийлэх, гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой. Бусдад нөлөөлөх 6 хэсгийн ахлагч хамрагдсан.<br>8.”Зүлэгт” 12 дугаар багийн фэзсбүүкт хорт зуршил, мансууруулах бодисын хэрэглээг багасгах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн 9 постер байршуулсан. | | |
| 8. | Арга хэмжээ 1.8.Хүүхэд өсвөр үеийг осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | 1.8.1.Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоогоор | 2 | 5 | 1.Арвайхээр сумын ЗДТГазраас “Хүүхдээ сонсох өдөр” зохион байгуулагдаж ЕБ-ын 4 дүгээр сургуулийн ахлах ангийн 20 сурагчаас санал, хүсэлт авч ажилласан.<br>2.Багийн ажлын албанаас санаачлан Цагдаагийн газар болон Политехник коллежи, ХГБХХГазартай хамтран “Хууль-Миний хамгаалалт” сургалт зохион байгуулсан.Сургалт нь найз нөхдийн нөлөө, сэтгэл зүйн дэмжлэг, суралцагчдын эрх зүйн үндсэн ойлголтыг нэмэгдүүлж, зөрчил болон гэмт хэргийн ялгааг ойлгож аливаа гэмт хэргээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, хамт олонч хандлагатай, зөрэг харилцааг төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн сургалт байв.Сургалтад 1 дүгээр дамжааны 15-18 насны 103 суралцагч оролцсон.<br>3.Долоодугаар сард аялал, амралт зугаалгын цаг ирсэнтэй | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдуулан үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд Арвайхээр сумын ЗДТГазраас гаргасан хуваарийн дагуу хяналтаар 2 удаа Олон довын гарам, Онгийн гол, Дайргын голын эрэг дагуух малчин айл өрх, аялагч, амрагчдад үер усны ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч, тараах материал тараан, хяналт тавин ажиллав. Иргэд, аялагч, амрагчдад баталгаатай зам гүүрээр зорчих, гол усны эрэг орчим байрлахдаа бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ голын усанд орохгүй байх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохоос татгалзах зэрэг урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг хүргэн ажиллав. Голын эрэг дагуух малчин 12 өрх, амарч зугаалж байгаа 149 иргэнд “Үер усны аюулаас сэргийлэх”, “Архи, согтууруулах ундаанаас татгалзах”, “Хүүхдийн тусламжийн 108”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”,“Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх” 1 боршур “Хүүхдийг харгалзах хүнгүй орхихгүй байх”, “Усны аюулын талаар хүүхэдтэйгээ ярилцъя”, гэх мэт 7 төрлийн 342 ширхэг тараах материал бэлтгэж тараан ажилласан.<br>4.”Зүлэгт” 12 дугаар багийн 1500 дагагчтай Facebook хуудсанд багийн ажлын албанаас хүүхдийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ахуйн осол болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх пост 7, эцэг эхчүүдэд өгөх зөвлөмж, гол усны ослоос урьдчилан сэргийлэх, хүүхдийг харгалзах хүнгүй орхихгүй байх, дэлгэцийн хамаарлаас хүүхдийг урьдчилан сэргийлэх гэх мэт постерууд сторид 22, хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлсэн бусад байгууллагын нөлөөллийн постыг 15 шейр хийсэн.<br>5."Аюулгүй орчин-Аз жаргалтай хүүхэд" 7 хоногийн аяны хүрээнд 12 дугаар багийн тоглоомын талбай, 4 дүгээр сургуулийн орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, холбогдох байгууллагад уламжилсан. | | |
| | | 1.8.2.Нийтийг хамарсан баяр, тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 6 | 1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан "Хайр түгээе-Инээд бэлэглэе" арга хэмжээ зохион байгуулж хандиваар цугласан 70 ширхэг бэлгийг зорилтот бүлгийн 70 хүүхдэд өгсөн.<br>2.Хүүхдүүдийн дунд сагс, волейболлын тэмцээн зохион байгуулж зааланд үнэ төлбөргүй 38 хүүхэд тоглуулсан.<br>3.Арвайхээр сумын улсын тэргүүний 3-р цэцэрлэгийн урлаг зааланд эцэг, эхчүүдийг хүлээн авч "Гэр бүлийн үнэ цэнэ" сургалт зохион байгуулж нийт 53 асран хамгаалагчдыг хамруулсан.<br>4."Өвөрхангай марафон-2025" бүх нийтийн гүйлтийн арга хэмжээ | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулагдсан. Гүйлтэд 3, унадаг дугуйн 5 км төрөлд 6 нийт 9 хүүхэд оролцсон.<br>5.Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Арвайхээр сумын ЗДТГазартай хамтран "Хүүхдийг зодох шийтгэхийн эсрэг өдөр"-ийг тохиолдуулан "Харицулагатай эцэг, эх байя" сургалт зохион байгуулагдаж 8 иргэн хамрагдсан.<br>6.Олон улсын "Охидын эрхийг хамгаалах" өдрийг тохиолдуулан 1, 9 дүгээр багтай хамтран "Пинк дэй" арга хэмжээ зохион байгуулсан.Арга хэмжээнд хамран сургах тойргийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 6,7,8 дугаар ангийн 185 охид оролцсон. | | |
| 9. | Арга хэмжээ 1.9.Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах | 1.9.1.Бэлгийн замаар дамжих халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан иргэдийн хувиар | 30 | 100 | 1.506 өрхийн 1737 иргэн байна. Үүнээс 18-60 насны 854 иргэн байгаагаас эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд 44 иргэнийг хамруулсан.Энэ насны иргэдээс эрт илрүүлэгт хамрагдах хүсэлт ирж БОЭТөвд үзлэг шинжилгээнд хамруулсан. 854 иргэдийн 5,2 хувь нь хамрагдсан.<br>2.18-аас дээш насны 991 иргэн байгаагаас "Уянсэтгэл" ӨЭМТөвд урьдчилан сэргийлэх үзлэгт чихрийн шижин 413,артерийн даралт 604, хөх 351, элэгний хорт хавдар 184, умайн хүзүүний хавдарын эрт илрүүлэгт 124 иргэд хамрагдсан.<br>2.Уянсэтгэл ӨЭМТөв нь БОЭТөвтэй хамтран нөхөн үржихүйн насны | 2025.01.02<br>2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эмэгтэйчүүдийн эхо үзлэг зохион байгуулсан.Үзлэгт 36 эмэгтэй хамрагдсан.<br>3.Арвайхээр сумын ЗДТГазраас “Эрчүүдийн эрүүл мэнд” арга хэмжээ зохион байгуулагдсан. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, зан үйлд эерэг нөлөө үзүүлэх, тэдний өөрийгөө хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн анхан шатны үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилготой.Тус арга хэмжээний хүрээнд 5 эрэгтэй хамрагдаж эрэгтэйчүүдийн эмчийн үзлэгт орон зөвлөгөө авсан.<br>4.Арвайхээр 5 дугаар багийн ажлын албанаас “Ахмадын инээмсэглэл бидний бахархал” сургалт, үзлэг арга хэмжээг БОЭТ-ийн Шүд, эрүү нүүрний тасагтай хамтран зохион байгуулсан.11 ахмад оролцсон.<br>5.”Элбэрэлт мед” эмэгтэйчүүдийн эмнэлэгт хөгжлийн бэрхшээлтэй 7 эмэгтэйг үзлэгт хамруулсан.<br>Үзлэг шинжилгээнд 1676 хамрагдсан нийт иргэдийг авч үзвэл давхардсан тоогоор 100 хувь хамрагдсан байна. | | |
